

ЗӨВЛӨЛТ, ХЯТАД ХОЁР МОНГОЛД ӨРСӨЛДСӨН НЬ

Т.Төмөрхулэг

Монгол Улсын Их Сургууль. Түүхийн судалгааны хүрээлэн.

Өгүүлийн товч утга: Энэ өгүүлэлд 1950-1960 оны эхэн хуртэлх хугацаанд ЗХУ, БНХАУ хоёр Монголын төлөө ямархан хэлбэрээр, аль хир далацтай өрсөлдөж байсаныг түүхийн баримт сэлтэд дулдуудан тодруулахыг оролдов.

Түлхүүр уг: ЗХУ-БНМАУ, БНХАУ-БНМАУ-ын харилцаа.

Хятадад олон жил үргэлжилсэн иргэний дайны эцэст буюу 1949 онд коммунистууд засгийн эрхэнд гарч БНХАУ тогтносныг Монголын засгийн газар даруй хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон нь Монгол Улс түүнээс дөрвөн жилийн өмнө Гоминданы Хятадаар хүлээн зөвшөөрүүлсэн тусгаар тогтонох эрхээ Хятадаар нэгэн ёсондоо баталгаажуулсан хэрэг болов. Нэгөөтэйгүй 470 километр урт газраар хилэлдэг урд хөршид нь улс төрийн тогтвортой байдал буй болоход Монголд аль ч талаар ашигтай байв. Тэр үеийн Монголын удирдагчид хоёр агуу их социалист хөршөөр хүрээлэгдсэн БНМАУ гаднаас айх аюулгүй болов хэмээн 1953-1956 онд урд хилийн цэргээ татан буулгажээ. Түүнчлэн Монгол-Хятадын хилийг дагуу байрлаж байсан цөөвтөр тооны орос цэрэг 1956 онд нутаг буцжээ.

1952 онд Сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайд Ю.Цэдэнбал тэргүүтэй төлөөлөгчид Бээжинд айлчилж Монгол-Хятадын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурсан билээ. Ю.Цэдэнбалын айлчлалын дунд Хятадаас ажиллах хүчин авахаар тохирч 1955 онд тусгай хэлэлцээр байгуулсан юм. Хятадын засгийн газар Монголтой худалдаа, эдийн засаг, соёл, хүмүүнлигийн хэлхээ холбоог өргөтгөхийг ихэд эрмэлзэн Ю.Цэдэнбалыг Бээжинд айлчлахад нь Мао Зедун бээр Хятад Монголын хөгжлийг 200 гаруй жилээр хойш татсан, танайд их өртэй¹ гэх зэргээр ярьсаныг тухайн үеийн Монголын удирдагчид олзуурхан хүлээн авсан бөгөөд Хятад Ард Улс Монголын социалист байгуулалтад үнэн сэтгэлээсээ туслах нь гэж найдсан нь Цэдэнбал Бээжингээс буцаж ирээд намын идэвхтэн хариуцлагатнуудад их л урамтай ярьснаас² тодорхой байдаг. Хожим 1962 оны өвөл болсон МАХН-ын Төв Хорооны II бүгд хуралд Д.Төмөр-Очир шүүмжлэл тавихдаа, тухайн үед Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга байсан Л.Цэндийг мөн л Маогийн тэр үгэнд итгэж явсан гэжээ³. Төмөр-Очирэн ярьсанаас үзэхэд Монголын удирдагчдын хэн нь ч тэр талаар урьд өмнө ац бодолгүй байсан нь мэдэгддэг.

Хятадад 1993 онд хэвлэгдсэн "Гадаад Монголын тусгаар тогтолын нууц үгсэл" номоос үзэхүүл, 1949 оны өвөл Мао Зедун Москвад айлчилж Сталинтай уулзахдаа, Гоминданы засгийн газар, ЗХУ-ын засгийн газрын 1945 онд байгуулсан Найрамдал, холбоотны Гэрээг хүлээн зөвшөөрөхгүй хэмээн мэдэгдэх аргаар БНМАУ-ыг Хятадад нэгтгэх санаагаа илэрхийлсэн агаад Маогийн хэлмэрч Ши Жэгийн хожим дурсан ярьснаар, Мао тэр үед Сталинд Монголыг авахаар зүрхлэн ам нээгээгүй авч, Жоу Эньлайн тэргүүлсэн төлөөлөгчид Микоянтай албан ёсны хэлэлцээ хийхдээ уг асуудлаар маргалдаж, зөвлөлтийнхний байр суурь хөдлөхгүй мэдээд Мао нэлээд хилэгнэсэн зэргийг Монголын удирдагчид тэр үед тааварлаа ч үгүй явсан мэт. Тэр ч атугай 1936 онд Мао Америкийн сэтгүүлч Эдгар Сноуд Монголын талаар ярьсан зүйлийг Улаанбаатарын удирдагчид мэдэж байсан эсэх нь тодорхойгүй. Гэтэл 1949 оны 9 дүгээр сард маршал Чойбалсан Сочид Сталинтай уулзсаныхаа дүнг МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүд, орлогчдод танилцуулах маягаар

¹ Хувийн архив

² Хувийн архив

³ Үнэн сонин, 1992-12-4

ярихдаа, Хятад чөлөөлөгдсөний дараа Монголыг өөртөө нэгтгэх асуудлыг Мао Сталинд тавьсан тухай дурдсаныг Цэдэнбал чихээрээ сонссон авч төдий л эмзэглээгүй өнгөрсөн шиг байдаг. Хятадын удирдагчдын Монголын талаархи санаархлыг 1956 онд Микоян Цэдэнбал албан ёсоор мэдэгдэхэд тэрбээр 1949 онд Чойбалсангийн тэр тухай ярьж байсан зүйл санаанд оров ⁴гэж хувийн тэмдэглэлдээ бичиж үлдээсэн буй.

ЗХУ, Хятадыг холбосон төмөр замыг Улаанбаатараар дайруулж тавих эсэх талаар Зөвлөлт, Хятадын удирдагчдын хэлэлцээ бэрхшээлтэй тулгарч байсан юм. Үүнд 1957 онд Мао Москвад айлчлах үеэрээ, олон улсын тэрхүү шугамыг нэг их чухал бус гээд баруун талаар Бээжингээс Урумчийг дайруулан Казахстанаар дамжсан төмөр замыг оросуудаар бариулахыг Хрушевт санал болгож байсан нь түүний дуртгалд буй бөгөөд Маогийн тэрхүү бодол эдийн засгийн үр ашгаас гадна Монголын асуудалтай дам холбогдож байсныг үгүйсгэж бас болохгүй бизээ. 1956 онд ашиглалтад орсон энэ төмөр замаар Зүүн Европын социалист оронууд, ЗХУ бараа таваараа Хятад руу зөөж байсан агаад Монголын жилийн төсөвт 45 сая төгрөгийн орлого оруулж байжээ. 1952 онд Ю.Цэдэнбал Бээжинд айлчлахынхаа өмнө сүүлчийн удаа Сталинтай уулзаж ярилцахад Сталин ярианы эхэнд, хятадууд төмөр замын шугамын дагуу байгалийн баялаг илрээгүй байсан ахул Улаанбаатарыг дайруулан төмөр зам тавихгүй байсныг өгүүлсэн нь цаагуураа Хятадаас сээрэмжлэх санаа төрүүлэх гэсэн болов уу. Сталин Цэдэнбалын янзыг үзэх гэсэн мэт дипломат маягаар "Хятадтай сайн харилцаатай юу?" гэж асуусан үгийн хариу болгож хэлэхдээ, "Сайн харилцаатай. Зөвхөн хүн амын /Монголын/ хоцрогдсон хэсгийн дотор заримдаа эрүүл бус санаа бодол үзэгддэг" гэсэн нь хятадын коммунистуудад лав ангийнхаа үзлийн үүднээс хандаж итгэж байсан нь илэрхий.

Тэр үед Хятадын нэлээд олон удирдагч манай элчин сайд Б.Жаргалсайханд Хятад, Монгол хоёр нэг гэр бүлд багтаж байсан гэж төрөлсөх маягаар ярьдаг байжээ. Жишээлбэл, БНХАУ-ын Ардын Төв засгийн газрын Төрийн захиргааны өрөнхий сайдын орлогч, Хөнгөн үйлдвэрийн Яамны сайд Хуан Ян Пи гэгч 1950 оны 7 дугаар сард Б.Жаргалсайханд "манай хоёр улс нэг гэр бүл байсан юм... манай улс 5 жилд сэргээн босгох ажлаа гүйцээгээд дараагийн 5 жилд улам цэцэглэн хөгжинө. Арван жилийн дараа бид нар нэг гэр бүл болно"⁵ гэх зэргээр ярьсан буй. Монголын удирдагчид иймэрхүү ярианд өөнтөглөлгүй, бодь сэтгэлээр хандаж байсан шинжтэй. Гэвч Цэдэнбал хожим хойно Монгол, Хятадын харилцаа эрс муудсан үед Хятадын тухайд Чойбалсангийн анхааруулж хэлсэн үгийг тухайн үед ойшоогүйгээ харамсч ярихдаа, пролетарийн интернационализмын зарчимаар хүмүүжсэн хүний хувьд маршалын үгийг тухайн үеийн настайчуудын яриа гэж боддог байсан гэжээ. Маршал бээр Монголын талаарх хятадуудын санаархлыг Цэдэнбалд цаагуураа ухааруулах гэж оролдож байсан хэрэг бололтой.

1952 оны эхээр Х.Чойбалсан Москвад мэс засал хийлгэн мөнх бусыг үзүүлэв. Түүнийг наснаас нөгчсөнөөр өвөр монголчуудыг БНМАУ-д нэгтгэх бодолтой байсан улс төрийн удирдагч Монголд дуусвар болоод Кремлийн хувьд ч Хятадтай харилцахад төвөг учрахгүй нэгэн ёсны амар болжээ. Үнэн хэрэгтээ 1945 оноос, улмаар БНХАУ байгуулагдсан 1949 оноос хойш Өвөр Монголыг БНМАУ-д нэгдэнэ гэдэгт Чойбалсан бүр ч найдахаа больсон бололтой. Учир нь гэвэл Монголыг ЗХУ-д нийлүүлэхээр Улсын прокурор Б.Жамбалдоржийн 1944 онд гаргасан саналыг тэрбээр Цэдэнбалын зөвлөсний дагуу Сталинтай 1949 онд ярилцахдаа, Дотоод Монголтой нэгдсэн цагт БНМАУ ЗХУ-д нэгдэж болох эсэхийг сэргүүлэх маягаар тандан асууснаас үзэхэд мэдэгддэг юм. Үүнийг батлах өөр нэгэн баримт гэвэл Х.Чойбалсан Ар Монголтой нэгдэх гэсэн Дэ ванг

⁴ Ю.Цэдэнбал. Гэрэл сүүдэр. Хувийн тэмдэглэл. УБ., 1994. 94 дэх тал

⁵ ГХЯ-ны архив. Фн № 5, х/н № 95, 101 дэх тал

/Дэмчигдонров/ Жоу Эньяайн шаардлага ёсоор ямар ч эсэргүүцэлгүйгээр Хятадад шилжүүлж өгсөн хийгээд "монгол хүний хувьд би та нарыг наашаа гэхээс цаашаа гэхгүй, гагцхүү дэлхий дахины олон улсын байдлаас шалтгаалаад болохгүй байна" гэж 1945 оны 10 дугаар сард Өвөр Монголын төлөөлөгчдөд учирлан өгүүлсэн нь яагаад ч хөдлөх аргагүйгээ ухаарсан хэрэг байжээ. Чойбалсан "дэлхий дахины одоогийн байдлаас шалтгаалаад "хэмээн ярьсан нь Хятадын хувьд явуулж буй 3ХҮ-ын бодлого, БНМАУ-ын статус-квогийн талаар Ялтад болсон турван гүрний тэргүүн нарын шийдвэр зэргийг битүүхэндээ зааж хэлсэн нь гарцаагүй юм.

БНМАУ-ыг 3ХҮ-д албан ёсоор нийлүүлэхийг 1944, 1950, 1953 онд санал болгосон хүмүүс хийгээд тэр саналыг дуртайяа дэмжигч нарын тухайд зарим судлаачийн бичсэнээр, тэдний бодолд Монголыг яаж хурдан хөгжүүлэх вэ гэсэн эх оронч санаа тод харагддаг, гэвч, өөрийн ард түмний тусгаар тогтолоо хамгаалах хүч бололцоог дутуу үнэлсэн хандлагатай гэх зэргээр дүгнэснийг анхааран үзэж болох л юм. Гэхдээ үүнийг арай дэлгэрүүлэн авч үзэх юм бол, 3ХҮ дэлхийн хоёрдугаар дайнд ялж олон улсын хэмжээнд ихээхэн нэр хүндтэй болсон агаад "коммунизмыг үсрэнгүй, өрнүүн байгуулах замдаа орсон", Европ, Азийн хэд хэдэн оронд "социализм биөлэлээ олсон", "социализм хэдэн орны хүрээнээс хальж даян дэлхийд ялан мандах өдөр ойрхон болсон", "ялсан пролетариангийн туслалцаагүйгээр хоцрогдсон оронд социализм байгуулах бололцоогүй", "материал техникийн баазыг буй болгохгүйгээр социализм байгуулах тухай ярихын ч хэрэггүй", "ер нь социализмыг хүнд аж үйлдвэргүйгээр төсөөлөхийн аргагүй", "Зевлэлт засаг дээр цахилгаанжуулалтыг нэмбэл коммунизм бүтнэ" гэх зэрэг зөвлөлт маягийн поозонгийн уг Монголын нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудлыг боловсруулахыг хичээсэн цөөвтөр сэхээтэн хүний тархи толгойд бат шингэж, нөгөөтэйгүүр тэд бас Зөвлөлтийн харьяанд багтаж байсан Дундад Азийн оронуудын "улгэр жишээ"-гээр хий зоригжин Монголыг 3ХҮ-ын бүрэлдэхүүнд албан ёсоор багтааснаар уг асуудлыг хэрэгжүүлж болох мэтээр төсөөлөхөд хүргэсэнийг "нэгдэх" гэсэн үндэслэлээс нь төвөггүй мэдэж болох юм. Үүнийгээ зөвтгөх тэдний өөр нэгэн шижим нь гэвэл марксизм-ленинизмийн сургаал ёсоор "тер мөхөхийн онол" юм. Энийг нутлах жишээ гэвэл, 1940-еөд оноос хойш дэвшсэн МАХН-ын удирдах хүмүүс "БНМАУ социалист төрийн хувьд мөнх орших бус"⁶, дэлхий дахины аж ахуйн хоршоолол үүсээд ирэхлээр монголчууд тэр хоршоололд элсэн орно гэж үзэж байсан агаад хожим 1960 оны Үндсэн хуульд БНМАУ ирээдүйд төрийн хувьд мөхөх тавилантай гэсэн утга санааг шургуулулжээ. Энэ нь даян дэлхийд коммунизм ялан мандах өдөр холгүй гэж Зөвлөлтөд сурталчилж байсны тусгал болотай. Иймээс тэднийг "эх ороносоо урвагчид" гэх юмуу, эсвэл "адал балмад явдалтангууд" гэж хочилж хараахан болохгүй биз. Харин тэднийг цаг үеийнхээ золиос болж төөрөлдсөн "сахалтай хүүхдүүд" хэмээн нэрлэвэл илүү таарах болов уу. Чухамдаа А.Амар нараас хойш Монголд тэр ёсны уламжлалын хэлхээ тасарч, хар бага наснаасаа "коммунизм"-ын оронд суралцан онолоор нь зэвсэглэсэн хийгээд туршлага нимгэн, эх ороныхоо үүх түүхийг олигтой судлаагүй, улс төрийн бодлоготны буйр суурь суугаагүй залуучууд нам, төрийн толгойд гарсаныг давхар харгалзан үзэх учиртай биз. Монголыг 3ХҮ-д нэгтгэх гэсний бас нэг болчимгүй тал нь гэвэл олон улсын харилцааны мөн чанарыг зөв ухаараагүй, тухайлбал түүхийн хувьд XVII зуунаас Монголын оршин тогтнож ирсэн нөхцөл байдал, geopolitikiin хүчин зүйл, ялангуяа Хаант Орос-Манж Чин улс, 3ХҮ-Хятадын улс төрийн харилцаанд болон стратегийн бодлогод монголын асуудал хэрхэн холбогдож ирсэн учир шалтгаан хийгээд тухайн цаг үеийн улс төрийн байдал, хэтийн төлөв, уг асуудалд бусад их гүрний хандлага

⁶ Ю.Цэдэнбал. Социалист Монголын хөгжил дэвшилийн түүхэн замнал, УБ, 1976.288 дахь тал

ямар байх зэрэгийг тун ч гадарлаагүйд оршино. Жишээлбэл, Монголыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаах гэсэн тэдний саналд, "Хятад улсад хувьсгал ялж ардын засаг тогтсоны ачаар манай тусгаар тогтносон байдал бүрэн баттай болсон явдал нь манай улсаас зөвлөлтийн холбоонд орох асуудлыг тавихад уудам чөлөөг тавьж өгсөн хэрэг даруй мөн хэмээн бид үзнэ"⁷ гэж их л гэнэн маягаар бичсэн зүйл буй. Ийнхүү улс төрийн бодлого, үзэл суртал хоёрын зааг ялгааг олж харах ухваргүй байсныг нь Зөвлөлт, Монголд ноёрхож байсан нийгмийн сэтгэлэгийн хоцрогдолтой уялдуулан авч үзэхээс өөр аргагүй.

Тэднийг тийнхүү Монголыг ЗХУ-д нэгтгэж "түргэн хөгжүүлэх" бодлогоо боловсруулж суухад БНХАУ-ын удирдагчид манай орныг аажмаар өөрийн болгох санаархлаа хэрэгжүүлэхээр хөөцөлдөөд эхэлчихсэн байжээ. Мао Зедун монголын асуудлыг ЗХУ-тай улс төрийн аргаар шийдвэрлэхийг зорихын сацуу тус орныг эдийн застгийн хамтын ажиллагаа болон бусад аргаар татахыг хичээсэн нь нэлээд баримтаар илэрхий болов.

Дээр дурдсанаар 1952 онд Ю.Цэдэнбал Бээжинд айлчилахдаа тохиролцсоны дагуу 1955 онд байгуулсан гэрээгээр Хятад Ард Улс 12200 мэрэгжлийн ажилчин нийлүүлэхээр болсоны 8000 орчим нь 1960-аад оны эхээр Монголд ажиллаж байжээ. Манай орон үнэхээр мэрэгжилтэй ажиллах хүчинээр мөхөстөх тул түүнээс ч өмнө Цэдэнбал гаднаас /ЗХУ-аас бололтой/ хүмүүсийг нүүлгэн оруулж ирүүлэх санаа сэдэж байсан⁸, тэгэхдээ буриад, туваа, халимаг зэрэг угсаатан юмуу, эсвэл өөр улс үндэстнээс юмуу гэдэг нь тодорхойгүй ажээ, гэвч энэ нь хэрэг дээрээ бүтээмжгүй гэдгийг ухаарсаныхаа дараа ЗХУ-д өөрийн орныг нэгтгэх саналыг дэмжсэн, Хятад Ард Улс байгуулагдмагц тийнхүү ажиллах хүч оруулж ирсэн, Хятадтай харилцаа муудмагц олон улсын социалист хөдөлмөрийн хуваарийг ашиглах, ЗХУ, ах дүү социалист оронуудтай ойртон нягтрал санаачлага дэвшүүлсэн зэргээр тэрбээр [үзэл баримтлалын уу?] хувьсал хөгжлийн их л ээдрээтэй замыг туулсан хэмээн түүхч Б.Сумъяа "Гэрэл, сүүдэр" номын оршилд тэмдэглэжээ. Хүн ам хэтэрхий цөөхөн тул Хятадаас өвөр монголчууд, ЗХУ-аас торгууд, буриад зэрэг ястаныг Монголд нүүлгэн оруулж ирэхээр 1920-иод онд Жамсралы Цэвээний гаргаж байсан санал болон Цэдэнбалыг дээрх оролдлогыг авч үзэх юм бол Монголын бодит бэрхшээл зовлонг аль аль нь адилхан амсч байжээ гэлтэй.

Тавиад оны дунд үе болоход Монгол Ард Улс хоёр агуу их хөрштөөгөө хамгийн өргөн хамтын ажиллагаатай орон болов. Гадаадын хэвлэлд нэлээр хожимын үед ч гэсэн "ЗХУ Монголд давамгайлж байгааг Хятад үл тэсвэрлэн 1950-иад оноос тус орныг битүүхэндээ булаацалдан хөрөнгө мөнгө, хүн хүчинээр тусалж эхэлсэн билээ"⁹ гэх зэргээр бичиж байв. Иймэрхүү утга санаа бүхий зүйл Өрнөдийн оронуудын хэвлэлд олонтаа нийтлэгджээ. ЗХУ, БНХАУ хоёр Монголын төлөө өрсөлдсөн үү, үгүй юу гэдэг нь маргах зүйл биш хэмээн үзэлтэй. Гэхдээ энэ өрсөлдөөн чухам ямар хэлбэрээр, аль хир далайцтай өрнөж байв гэдэгийг тусгайлан авч үзэх нь өгүүлэгдэн буй гурван орны харилцааны түүхийг тодотгоход ч нэмэртэй гэдэг нь мэдээж. Тэр тусмаа 1950-1960 он бол Монгол-Хятадын харилцааны түүхэнд онцлог зурvas үе юм.

1950-иад оны дунд үе болоход Монгол-Хятадын худалдааны эргэлт огцом өсч Хятад Монголын гадаад худалдааны хоёр дахь түнш болжээ. Тухайлбал, 1955 онд тус хоёр ороны худалдаа 1950 оныхтой харьцуулбал 3-4 дахин өссөн бол 1956 онд 2-3 дахин нэмэгдсэн байна¹⁰. 1956 оны 8 дугаар сарын 29-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан БНХАУ-аас БНМАУ-д эдийн засаг, техникийн тусламж үзүүлэх хэлэлцээр ёсоор 1956-1959 онд Бээжингийн засгийн

⁷ Үнэн сонин, 1990-8-8

⁸ Ю.Цэдэнбал.Гэрэл сүүдэр.Хувийн тэмдэглэл, 9 дэх тал

⁹ Letter of Ulan-Bator, by T.E.Event, Far Eastern Economic Review, September 14, 1979

¹⁰ Женьминьжикао, 1956-8-30

газар Улаанбаатарт 160 сая рублийн буцалтгүй тусламж үзүүлжээ. 1960 оны 5 дугаар сард БНХАУ-ын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Жоу Энълайн Монголд хийсэн айлчлалын явцад Найрамдал, хамтын ажиллагааны Гэрээнд гарын үсэг зурсаны сацуу Хятад улс Монголд 200 сая рублийн удаан хугацааны зээл олгох болж, энэхүү зээлийн хөрөнгөөр аж үйлдвэрийн газар, усжуулалт болон нийгэм ахуй, зам тээврийн барилга байгууламж барьж байгуулах үүрэг хүлээжээ. Жоу дарга Монголд хүнд аж үйлдвэр байгуулах, тариалангийн аж ахуй эрхлэх, улмаар хүн амаа ёсгөхийг нэн чухалчлан ярьсан юм. Хүн амын тухайд гэхэд Монголд ажиллаж байсан хятадуудыг тус орны цаг агаар, ахуй нөхцөлд дассаных нь хувьд хэрэв өөрсдөө хүсвэл суурьшуулж болох тухай хувийн саналаа Цэдэнбалд хэлж байжээ. Монгол-Хятадын Найрамдал, хамтын ажиллагааны хэлэлцээрийн З дахь зүйлд, "Хэлэлцэн тохирогч хоёр тал тус хоёр улсын энх тайван, бүтээн байгуулалтын үйлст бие биедээ бүхий л чадлынхаа хирээр эдийн засаг, техникийн туслалцаа үзүүлэх болно" гэж заасныг дурдаж болно. Үүнтэй холбогдуулан архивийн хэрэглэгдэхүүнээс үзвэл, Жоу дарга 1952 онд Цэдэнбалд аминчлан хэлэхдээ, "манайхаас юу хэрэгтэй вэ, тэрийгээ тухай бүрд ах дүүгийн ёсоор нэрэлхэлгүй хэлж байхыг хүснэ. Бид аль чадах чинээгээрээ туслана"¹¹ гэж байжээ.

Тийн авч Монгол дахь Зөвлөлийн эдийн засгийн нөлөө үлэмжхэн хэвээр байсныг доорхи тоо баримтаас харж болно. Үүнд, 1952-1962 онд ЗХУ БНМАУ-д 725 сая ам. Долларын зээл тусламж олгосон ахул БНХАУ-ынх 115 сая ам долларт хүрчээ¹². Монголын албаны хүмүүсийн хийсэн тооцогоор, зөвхөн 1947-1957 онд ЗХУ Монголд 900 сая гаруй рублийн урт хугацааны зээлийг хөнгөлөлттэйгээр олгосон ажээ¹³. Тэгвэл 1962 оны байдалаар ЗХУ 6-7 дүнчүүр хүн амтай Ардын Хятадад ердөө 1,7 тэрбум рублийн зээл өгсөн байгаа юм.

Хоёр их гүрний Монголд үзүүлж байсан зээл тусламжийн ялгарах нэг онцлог гэвэл ЗХУ-ынх тус орны өргөн уудам нутагт олон салбарт цацагдаж үр өгөөж нь тааруухан мэт үзэгдэж байсан бол Хятад тодорхой салбарт нүдэнд тусахуйц тесөл хэрэгжүүлэхийг хичээж байв. 1956 оны хавар ЗХУ-ын Дээд Зөвлөлийн тэргүүлэгчдийн дарга К.Е.Ворошилов Улаанбаатарт айлчлахдаа Монголын удирдагчдад ярьсан зүйлээс болон МАХН-ын Төв Хороонд аж үйлдвэрийн асуудал эрхэлж агсан Ц.Гүрбадамын хожим хэвлэлд нийтлүүлсэн өгүүлэлзээс үзэхэд ЗХУ тэр үед Монголд хүнд аж үйлдвэр байгуулах шаардлагагүй гэж байсан бол 1960 онд Жоу Энълайн айлчлалаар Хятад Монголд төмөрлөгийн үйлдвэр байгуулахаар тохиролцсон байгаа юм. 1960 онд Жоу Энълай Ю.Цэдэнбалтай албан ёсны хэлэлцээ хийхдээ "танай байдлаас хараад хүнд аж үйлдвэр байгуулах шаардлага байна" хэмээн ярьсан¹⁴ бөгөөд Жоу даргын айлчилалд зориулсан хөдөлмөрчдийн цуглаанд Ю.Цэдэнбал, Хятадыг бага, дунд хэмжээний хүчин чадал бүхий металлургийн үйлдвэр байгуулахдаа их туршилгатайг дурьдан "энэ туршилга нь манай оронд таарах юм"¹⁵ гэжээ. Тэр үеийн мэдэх хүмүүсийн яриагаар, Мао Зедун 1952 онд Бээжинд Ю.Цэдэнбалтай уулзахдаа, аж үйлдвэрийн асуудлыг хөндөж "таксаа гэхэд агач /үүлдэр мую/ биш, өндөглөдөг л байвал зүгээр дээ"¹⁶ гэсэн нь Зөвлөлийн Монголд үзүүлж байсан тусламжийг цаагуураа өгөөдсөн хэрэг байж ч болзошгүй. Үүнтэй уялдуулж өгүүлэхэд, 1940-өөд онд Улаанбаатарт Зөвлөлийн байгуулсан төмрийн заводыг Монголын зарим сэхээтэн хүй нэгдэлийн үеийн үйлдвэртэй адилтгаж байсныг дурдаж болох юм. /Жич:

¹¹ ГХЯ-ны архив.Фонд № 5, шифр № 385, 216 дахь хуудас

¹² Henry H.Covington. Sino-Soviet stakes in Mongolia, 1974. Air University, Maxwell Air Force Base, Alabama, p.17-19

¹³ ГХЯ-ны архив, фонд № 02, шифр 618

¹⁴ ГХЯ-ны архив, фонд № 05, х/н № 388, 7-33 дахь тал

¹⁵ Үнэн сонин, 1960-6-1

¹⁶ Хувийн архив

Хятадуудын барих ёстой байсан төмөрлөгийн үйлдвэрийг Монголын эдийн засагт ашиггүй гэж зөвлөлт нөхөд зөвлөсөн тухай мэдээ МАХН-ын гол хэвлэл Үнэн сонинд 1961 онд нийтлэгдсэн билээ.

1956 онд болсон ЗХУКН-ын 20 дугаар их хурлаар Н.С.Хрущев ЗХУ-д нэг хүнийг тахин шүтсэний хор холбогдлыг зад илчилж тус оронд нэг ёсондоо "урь унах" шинж төлөв мэдэгдсэнд Монголд шинээр бойжиж байсан сэхээтэнүүд, их, дээд сургуулийн оюутанууд зоригжин, ихэвчлэн Монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагааны зарим доголдолтой талыг шүүмжлэн хэлэлцэнийг МАХН-ын Төв Хороо Монгол-Зөвлөлтийн ган бат найрамдалд эргэлзсэн, үндэсээрхэг үзэл нэвт шингэсэн, улс төрийн хор хөнөөл бүхий үзэл бодол, "сэхээтэний төрөгдөл" хэмээн давшилж төдхөн дарж авчээ.

Тэгтэл зөвлөлтийнхөн Монголыг дөчөөд жил нөлөөндөө авч ирсэн их гүрний хувьд, нэгд, Монголын сэхээтнүүдийн дотор тэдний тусlamжийг чамлаж гоморхсон үг яриа гаргаснаас сэхээ авч, нөгөөтэйгүүр хятадууд энэ орныг өөрсдөөс нь нэхэж буйг /1954, 1956 онд хятадууд Монголыг авахаар Сталины дараах Зөвлөлтийн удирдагчдад санал болгосныг хэлж байна/ давхар бодолцон тус улсад бодитой тусlamж үзүүлэхийг бodoх болжээ. ЗХУКН, ХКН-ын хооронд нэлээд асуудалаар үүсч байсан зөрчил энэ үетэй давхцаж буйг мөн анзаарууштай юм. Монголыг өөд татах нь капиталист бус хөгжлийн онолыг сурталчлан шинээр тусгаар тогтнох буй Ази, Африкийн олон оронд үлгэр жишээ болно гэсэн ухуулгын холбогдолтой бас нэгэн сэдэв тэр цагт шинэвтэрхэн гарч ирээд байсныг умартаж болохгүй. 1957 оны 5 дугаар сард Москвад айлчилсан Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалын толгойлсон засагийн газрын төлөөлөгчидтэй хэлэлцээ хийхдээ Н.С.Хрущев "бид танайхтай 40 жил нөхөрлөхдөө дорвitoj юм бүтээж өгөөгүйдээ ичмээр байна" хэмээн ярьсныг уул төлөөлөгчидийн бүрэлдэхүүнд багталцсан тэр үеийн Гадаад явдлын Яамны сайд Д.Адилбиш бичиж үлдээсэн билээ¹⁷. Хрущев тэрхүү төлөөлөгчдөд "бид та нарыг муу мэдэж байжээ... Монгол бол түүхий эд нийлүүлдэг орон байж таaraхгүй... Бид Монголын тухай бodoх цаг болжээ" гэх зэргээр мэдэгдсэн нь Монгол-Зөвлөлтийн харилцаанд гарсан ихээхэн шинэлэг зүйл бөгөөд тус орныг дэмжиж тэтгэхийг цоо шинээр авч үзсэн хэрэг бүлгээ. Монголын төлөөлөгчдийн энэхүү айлчиллын дунд ЗХУ-ын засгийн газар манай засгийн газрын хүсэлтийн дагуу 300 сая гаруй рублийн өртөг бүхий "Монголнефть" трестийг үнэ төлбөргүй шилжүүлж, "Совモンголметалл" хэмээх хувь нийлүүлсэн нийгэмлэгийн зөвлөлтийн хувь хөрөнгийг манайд хөнгөлөлттэйгөөр худалданы гадна Монголд нийлүүлэх тоног төхөөрөмж, машин материал болон техникийн бусад тусlamжийн үнийн төлбөр нэрээр 200 сая рублийн урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох болжээ. 1959 оны 2 дугаар сард БНМАУ, ЗХУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай хэлэлцээ Москвад болж Монголд атар газар эзэмшихэд болон уг салбарт хайгуул шинжилгээний ажил гүйцэтгэхэд ЗХУ-аас БНМАУ-д тусlamж үзүүлэх тухай хэлэлцээр байгуулж билээ. Уг баримт бичигт Ю.Цэдэнбал, Н.С.Хрущев нар гарын үсэг зурсан юм. Энэхүү хэлэлцээр Монголын үр тарианы хэрэгцээг дотоодынх нь үйлдвэрлэлээр хангахад чиглэжээ. ЗХУ зөвхөн сүүлийн 12 жилд Монголд хөнгөлөлт бүхий, урт удаан хугацааны 1,2 тэрбум алтан рублийн зээл олголоо гэж тэр үед Ю.Цэдэнбал мэдэгдсэн юм¹⁸. Түүнчлэн БНМАУ-ын улс ардын аж ахуйг хөгжүүлэх 3 дугаар таван жилийн төлевлөгөөг биелүүлэх хэрэгт ЗХУ-аас 615 сая рублийн нэмэлт тусlamж үзүүлэх болсоны сацуу урьд зээлсэн 245 сая рублийн төлөх хугацааг хойшиулсан байна. Эл хэлэлцээрт 1960 оны 9 дүгээр сард гарын үсэг зуржээ.¹⁹

¹⁷ "Ертөнцийн чихнээ..." Монгол элч нарын дурсамж. УБ, 1991. 2 дахь тал

¹⁸ Үнэн сонин, 1959-2-28

¹⁹ Үнэн сонин, 1960-10-6

Дээрх тоо баримтаас үзэхэд тэр үед ЗХУ-аас Монголд үзүүлж байсан техник-эдийн засгийн тусламжийг БНХАУ-ынхтай харьцуулбал цар хүрээгээр нь ч, тоо хэмжээгээр нь ч зүйрлэхийн аргагүй бөгөөд 1962 онд Энэтхэгийн нэгэн сонинд бичсэнээр, өнгөрсөн таван жилийнх нь байдлаар авч үзэхэд Монголд өгсөн Хятадын тусламж ЗХУ-ын тусламжийн гуравны нэгд ойролцоогоор хүрэхтэй үгүйтэй байжээ.²⁰

Чингэтэл 1960 оны 5 дугаар сард Хятадын Төрийн Зөвлөлийн өрөнхий сайд Жоу Энъяй Монголд албан ёсоор айлчилж Найрамдал, харилцан туслах тухай Гэрээ байгуулсан хийгээд уг айлчиллаар Хятад Монголд үлэмжхэн хэмжээний зээл олгох болсон мэдээг Өрнөдийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр багагүй шуугиж Хятад, ЗХУ хоёр Монголд бодитойгоор өрсөлдөж байна гэх буюу Монголыг Зөвлөлийн хүрээнээс ангижирч чухамдаа эх газрын Хятадын өвөр түрийд орж буй мэтээр ч бичиж байсан явдал буй. Чухамхүү тэр үеэр буюу 1960 оны 7 дугаар сард АНУ-ын "Юнайтед пресс" агентлагийн сурвалжилагч П.Спрайг Улаанбаатарт ирж Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалаас сурвалжлага авахдаа, "Хятад Улс өөрөө ЗХУ-ас тусламж авдаг мөртлөө Монгол Улсад яагаад эдийн засгийн тусламж үзүүлдэг юм бол?" гэсэн эгзэгтэй асуулт тавьсан юм. Ю.Цэдэнбал сурвалжлагад түүний хариуд, "Миний бodoход та энэ асуултаа Хятадын нөхдөд тавих хэрэгтэй байсан юм" гээд социалист оронуудын хоорондын хамтын ажиллагаа чин шудрага хэмээн нутлахыг оролдсон байдаг юм.²¹ Түүнээс хойш гурван жил өнгөрөхөд ЗХУКН, ХКН-ын үзэл сурталын зөрчил улс хоорондын харилцаанд нь тусаж, МАХН ямар нэгэн эргэлзээгүйгээр ЗХУ-ыг туштай дагахаа 1963 онд болсон Төв Хорооны бүгд хурлаар батласан баримт бичгээрээ зарлаад байв. Яду зүдүү орныхоо эрх ашгийн үүднээс ЗХУ, БНХАУ-ын аль алинтай нь эв зүйг бодолцон учиртай харилцах ёстой байсан юм гэсэн утгаар 1964 оны өвөл болсон МАХН-ын Төв Хорооны бүгд хуралд Ю.Цэдэнбалыг шүүмжлээд уг бүгд хурлаар "намын эсрэг бүлэг"-ийн гол толгойлогч гэсэн нэр хоч зүүж намаасаа хөөгдсөн Ц.Лоохууз хожим олон түмэнд ярихдаа, тавиад оны эцэс, жараад оны эхэн үед хоёр их хөрш маань манайд өрсөлдөж байгаа мэт сэтгэгдэл төрдөг байсан, тэрхүү өрсөлдөөнийг ашиглах ёстой юм хэмээн би боддог байсан гэж билээ. Далаад оны эхээр Улаанбаатар дахь Зөвлөлийн ЭСЯ-ны нэгэн зөвлөх ГХЯ-ны орлогч сайд Д.Ёндөнд хамтын ажиллагааны асуудлыг хөндөн, БНХАУ-аас Монголд тусламж үзүүлж эхлэхэд ЗХУ-аас илүүтэй туслаж байгаа мэт харагддаг байсан, жишээлбэл, зөвлөлийнхөн 40 мянган ам метр орон сууц барина гэхэд хятадууд 50 мянган ам метр орон сууц барина гэсэн гэх зэргээр ярьсан нь "Алтан аргамж" 1996 номд орсон түүний дурсамжид буй. Чингэхээр алс холын гадаад улсуудад байтугай Улаанбаатарт ч ЗХУ, Хятад хоёрыг Монголын төлөө өрсөлдөж байна гэж ямар ч гэсэн өнгөн талаас нь тэр үед бодохоор байжээ. Хятадууд Монголд их идэвхтэй ажиллаж байсан нь ач тач өрсөлдөж байна гэж үзэхийн гол шалтгаан болсон бололтой.

Монголын гадаад худалдааны тухайд гэхэд л ЗХУ зонхилох байр суурийг эзэлсэн хэвээр байв. Тавиад онд Хятадаас ажиллах хүчин авах Монголын талын санаачилгыг Кремлийн удирдагчид зөвшөөрсөн нь хэдийвээр хятадууд Монгол руу хараагаа чиглүүлсэнийг мэдэвч хардаж сэргсэнгүй, санхүү-эдийн засгийн туслалцаа авахыг нь ч цааргалсангүй нь аль хэдийнээс ЗХУ Монголд улс төр, цэрэг, эдийн засагийн хувьд байр сууриа бэхжүүлчихсэн тул нэг их сандралгүй, Монголын өмнө үүрэг хүлээсэн улсын хувьд өгөх тусламжийнхаа зарим хэсгийг харин ч Хятадаар үүрүүлж хөнгөвчлөх арга ухаан сийлж байж уу гэж үзүүштэй. Нэг ёсондоо Хятад хичнээн зүтгээд Монголыг авч чадахгүй гэдэгт оросууд бат итгэж байсан нь маргаангүй. Тэр үес ЗХУ өөрийгөө социалист лагерийн

²⁰ New Delhi April 4, 1962

²¹ Үнэн сонин, 1960-7-20

толгойлогч гэж үздэг байсан бөгөөд үнэхээр ч лагерь дотроо цэрэг-эдийн засагийн хувьд хамгийн эрдүү бярдуу гүрэн байв. Иймээс ЗХУ-ыг Монголд Хятадтай тавиад оны эхээр “идэшээ булаацалдаж буй хээрийн амьтан”-ы дүр төрхөөр өрсөлдөж байсан гэж үзэж хараахан болохгүй мэт. Оросын өрсөлдөөн бол алсуур, даацтай хэлбэрээр илэрч байсан гэж хэлж болох юм. Хоёр орны /ЗХУ, БНХАУ/ эв түнжин илэрхий хагарсан жараад оноос ЗХУ Монголтой харилцахдаа хятадын хүчин зүйлийг ямагт бодолцож байсан нь түүхэн үнэн юм. Үүний нэгэн тод жишээ гэвэл ЗХУ, БНМАУ-ын Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах тухай 1966 оны Гэрээ билээ. Олон зуун сая хүн амтай Дундад Улстай хаяа нийлэн оршиход Ар Монголыг бамбай бүсээ болгох нь ирээдүйтэй гэж тооцсон Хаант Оросын дипломатуудын гөостратегийн баримтлал Зөвлөлтийн үед уламжлагдан ирээд тэр нь тус их гүрэний Алс дорнодын бодлогод байр суурь эзэлсэн хэвээр байв. Эл баримтлал шинэ цаг үед буюу ХХI зуунд ч хуучраагүй гэдэг нь ойлгомжтой болов.

Өгүүлэгдэн буй Монгол-Хятадын шинэ Гэрээний талаарх АНУ-ын Нууц мэдээллийн албаны нэгэн бичвэрт тулгуурлан Францын ГХЯ-наас дээд удирдлагадаа илгээсэн мэдээлэлд ЗХУ-БНМАУ, БНХАУ-БНМАУ-ын хоорондын аж ахуйн хэлхээ холбоог тоо баримтаар дурдан “Бээжингийн зүгээс Москвагийн Монгол дахь нелөөг ид сулруулж байна гэж үзэх ямар ч үндэслэл алга. Дарга Цэдэнбал Хятадын тусламжийг хүртчихээд өөрийн удирдах багш гэж үздэг ЗХУ-аа цаашид ч бараадна гэдгээ зориуд тодотгож мэдэгдсэн юм”²² гэж дурдсаныг энд жишээ татаж болно.

Ю.Цэдэнбал Монгол Улсын талаарх Хятадын дарга нарын далдуур явуулгын тухай 1956 онд ЗХУ-ын удирдагчдаас тодорхой мэдээлэл аваад дотор сэтгэлдээ Хятадыг үзэх хандлагаа өөрчилсөн нь лавтай. Энэ юугаар нутлагдаж байна вэ гэвэл, ах дүү оронуудтай хил хязгаараа тодотгохыг төдий л яардаггүй байсан тэрбээр БНМАУ, БНХАУ-ын хилийн гэрээг байгуулах саналыг 1957 оны 11 дүгээр сард хятадын талд тавьсан байна. Яардаггүй байсан гэдэг нь ямар учиртай вэ гэвэл Онц бөгөөд бүрэн эрхт элчин Б.Цэдэн-Ишийн өгүүлсэнээр, 1920-иод оноос умард хил эзгүйрэх болсоныг харгалзан судалгаа явуулах гэсэн ГХЯ, НАХЯ-ны хамтарсан саналыг жараад онд буруушаан буцааж байсан аж.²³ Үүнийг зөвлөлтийнхний сэтгэлзүйг мэдэрдэг асан тэр хүний болгоомжлолтой холбож тайлбарлахаас өөр аргагүй.

Архивийн баримтаас үзэхүүл Дундад Ард Улсын засгийн газар 1958 оны 3 дугаар сарын 28-нд Монголын засгийн газарт ирүүлсэн ноот бичгээр Хятад, Монголын хилийн хэлэлцээ хийх саналыг хүлээн авч байгаагаа мэдэгдэж, үүнээс дөрвөн жилийн дараа буюу 1962 оны 11 дүгээр сард Гэрээ байгуулсан билээ. Монгол Улс ийнхүү Хятадтай уг гэрээ байгуулсаныг өрнөдийнхөн санаанд оромгүй явдал гэж гайхаж байв. Зөвлөлт, Хятадын хооронд үүссэн зөрчлийг цаагуураа Монголтой холбоотой болов уу гэж таамаглах хандлага АНУ зэрэг улсад тухайн үед гарч байсан нь сэтгүүлч Солсберийн 1966 онд Монголын тухай бичсэн номоос ч үзэхэд тодорхой. Гэтэл монголч эрдэмтэн Роберт Рупен бичихдээ, чухамхүү 1958 оноос хятадууд Монголын хойноос мэрийж хөөцөлдөхөө зогсоож эхэлсэн гэжээ. Үүнд тэр үеийн Хятадын удирдагчид монголын асуудлыг зөвлөлтийнхөнтэй хэлэлцэж улс төрийн замаар шийдэх бодлоо огоорсон гэж Рупен хэлэх гэсэн шиг байна. Чингэвч хятадууд Монголтой эдийн засаг-санхүүгийн хамтын ажиллагаагаа өргөтгөж нелөөгөө аажмаар тусгахыг 1960 он хүртэл лав хичээснийг Жоу Энъяйн Улаанбаатарт хийсэн айлчлал гэрчилж буй. Нэгэн үгээр хэлэхэд Дундад Ард Улсын засгийн газар монголчуудтай “тулж ажиллах” аргыг сонгосон хэрэг болов уу гэж үзүүштэй.

²² Archives du MAEF 10bis-23-8: Relations avec la Chine Populaire

²³ “Алтан аргамж”. Монгол элч нарын дурсамж. УБ, 1996. 142 дахь тал

Цэдэнбалын засгийн газрын Хятадад үл итгэх бас нэгэн шалтгаан гэвэл Чингис хааны нэртэй холбоотой ажгуу. Юу вэ гэвэл хятадууд Өвөр Монголын Ордос нутагт Чингисийн онгон тахилгын сүмийг 1955 онд байгуулан мэндэлсэнийх нь 800 жилийн ойг 1962 онд сүртэй тэмдэглэхээр зэхэж байв. Энэ нь БНМАУ-ыг Өвөр Монголоор татах гэсэн Хятадын удирдагчдын эчнээ бодлогын нэг тал юм гэж тухайн үед Өрнөдийн улс төр судлаач, эрдэмтэд бичдэг байв. Чингисийн гавьяаг Хятадад өргөн мандуулах болсоныг Москвагийн удирдагчид хардан, алсуураа газар нутаг нэхэх нэгэн шалтаг хэмээн сээрэмжлэх болжээ. Монголын дарга нар ч бас үүнээс сэхээ авч Чингисийн терсений ойг тэмдэглэхээр МАХН-ын Төв Хорооны Улс териин товчооны тогтоол батлан Цэдэнбал ч гарын үсгээ зурсан байна. Ойг тэмдэглэх ажлыг тэр үед Төв Хороонд үзэл суртал хариуцаж байсан Д.Төмөр-Очир идэвхилэн хөөцөлдсөн гэдэг. Энэ ажлын хүрээнд болсон эрдэм шинжилгээний бага хуралд гол илтгэлийг тавьсан академич Ш.Нацагдорж агсан гадаадын нэг зохиолчтой 1993 онд ярилцахдаа, тэр үед Хятад Чингисийн байлдан дагуулсан бүхий л улсад нелөөгөө дэлгэрүүлэх бодлого баримтлах болсоны учир Чингис Монголын хаан бөгөөд Монгол бол Хятадаас ангид тусгаар улс байсаар ирсэн гэдгийг батлах үүднээс Монгол Улсад түүний 800 жилийн ойг эрхбиш тэмдэглэх шаардлага гарсаныг дурсан ярьжээ.²⁴

Эдгээр баримт сэлтээс үзэхэд Монголын засгийн газар хятадуудтай арга оньчтой үзэлцэж өөрийн улсын талаар тэдний санаархлыг зөрүүлээд /эдийн засагийн хамтын ажиллагааг өрнүүлж зээл тусламжийг нь авах аргаар/ өөрийн улсад ашигтайгаар эргүүлэх бодлогыг лав тавиад оны дунд үеэс жараад оны эхэн хүртэл баримталжээ гэж дүгнэж болохоор байна.

Abstract: The well-known historian and diplomat has attempted to prove in his article that there was a little chance for Chinese leaders to take over Mongolia in 1950-1960s. On one hand Soviet Union had strengthened its position in that country for decades and had no desire to let Mongolia out of its control for its own geo-strategic reasons. On the other hand, the then leadership of Mongolia conducted wise policy towards China by successfully redirecting Chinese advances to its own benefit. Ample facts and documents were used by the author to substantiate his views.

²⁴ Ил товчоо сонин, 1993.5.20-30 /Петер Ханам гэгч австрали зохиолчийн өгүүллийн орчуулга/